


“MUST Start-Up” тэмцээнд “ЛегоРобо” баг түрүүлэв.

Оюутны гарааны бизнесийн шинэ санаа, технологийн шилдэг шийдэл шалгаруулах “MUST Start-Up” уралдааны сүүлийн шат 5 дугаар сарын 20-ны өдөр болж өнгөрлөө. Сүүлийн шатанд 13 баг өөрсдийн дэвшүүлж буй санаа, технологийн шийдлээ танилцуулж, инноваци, гарааны компанийн экосистемийг Монгол улсад хөгжүүлж буй туршлагатай шүүгчдийн өмнө найраа (pitch) хийснээс ЛегоРобо, Darkhan IoT, Pelos багууд шилдэгээр шалгарлаа.

Тус арга хэмжээ нь жил бүр уламжлал болгон зохион байгуулагддаг “Монголын инновацийн 7 хоног”-ийн хүрээнд явагдсан бөгөөд ШУТИС-ийн Технологи дамжуулах төвөөс санаачлан Бизнесийн удирдлага, хүмүүнлэгийн сургуультай хамтран Боловсрол, шинжлэх ухааны яамны Инноваци, технологийн газрын дэмжлэгтэйгээр зохион байгуулагдлаа.



“MUST Start-Up” уралдаан гарааны бизнесийн олон улсад зохион байгуулагддаг аргачлалаар дараахи үе шаттай явагдлаа.

- Эхний шатны шалгаруулалт (шигшилт) – 5 сарын 6



- Энтрепренершип хөтөлбөр (Mentor day) - 5 сарын 8-15
- Сүүлийн шатны шалгаруулалт (Pitch day) - 5 сарын 20



Эхний шатанд нийт 41 баг шинэ санаа, технологи танилцуулж оролцсоноос 15 баг шалгарч энтрепренершип хөтөлбөрт хамрагдан сүүлийн шатанд ийнхүү 13 баг (Pitch day)-д оролцов.

Энтрепренершип хөтөлбөрийг ШУТИС-ийн Бизнесийн удирдлагын сургуулийн профессор Я.Оюунтунгалаг ахлан ажиллаж доктор Т.Сүмжидмаа, М.Бурмаа, Ц.Энхтуул, МУИС-ийн Бизнес консалтинг төвийн сургагч багш Н.Батсүх нарын багаас бүрдсэн туршлагатай сургагч багш нар хариуцан хэрэгжүүлэв.

Хөтөлбөр 5 сарын 8-наас 15-ны өдрүүдэд үргэлжилсэн бөгөөд багуудад шинэ санаа, технологио загварчлах сэтгэлгээний зүгээс (design thinking) авч үзэх, санаагаа бизнес загварт (business canvas) оруулах, хэрэглэгчээ баталгаажуулах, бүтээгдэхүн үйлчилгээний үнэ цэнээ тодорхойлох нь зэрэг агуулгын хүрээнд олон улсад гарааны компанийн санааг бойжуулдаг аргачлалаар явагдлаа. Мөн түүнчлэн энтрепренершип хөтөлбөрийн хүрээнд туршлагатай зочин энтрепренерүүдийн урьж оролцууллаа.



Сүүлийн шатны (Demo day) үйл ажиллагааг Zoom флатформ ашиглан цахим хэлбэрээр зохион байгуулсан олон нийтийн сүлжээнд нээлттэй байдлаар шууд дамжууллаа. Сүүлийн шатны арга хэмжээг нээж Боловсрол шинжлэх ухааны Инноваци техноллогийн газрын дарга доктор Д.Одгэрэл нийт оюутан судлаачдад амжилт хүсэж дараа дараагийн арга хэмжээнүүдэд мөн идэвхи санаачлагатай оролцохыг уриалав.



Сүүлийн шат SukiDo Z, Сивиллицкий –АэрЛети, Electron boys, Залуу инженерүүд, Мехатроник, ЛегоРобо, Easy Device, Pelos, Darkhan IoT, Solar trailer, MCM-17, Uncage, AIA гэсэн 13 багийн дунд болж багууд 5 минутанд санаагаа танилцуулж, шүүгчдийн асуултанд хариулах хэлбэрээр явагдав. Шүүгчдийн бүрэлдэхүүний ахлагчаар ШУТИС-ийн Эрдэм шинжилгээ, хамтын ажиллагаа эрхэлсэн дэд захирал Т.Намнан ажилласан ба бүрэлдэхүүнд Сократус стартап студио ХХК-ийн захирал А.Мөнхцог, Старт компанийг хамтран үүсгэн байгуулагч, гүйцэтгэх захирал Б.Пүрэвсүрэн, Нийслэлийн шинжлэх ухаан, үйлдвэрлэл, инновацийн газрын Инноваци, үйлдвэрлэлийн хэлтэсийн дарга Б.Урьболд, ШУТИС-ийн Бизнесийн ахисан түвшний сургуулийн салбарын эрхлэгч доктор Б.Оюунтунгалаг нар ажиллалаа.



1 YEAR



4+8

Хямд өртөг

3,000,000₮

Гаргасан зардал

10,000,000₮

Өндөр бүтээмж

40

✓ Түрээсийн зардал

✓ Цалингийн зардал

Your video is partially muted due to a copyright match. Only you can see this.

Шинжлэх Ухаан Технологийн Их Сургууль was live — at Шинжлэх Ухаан Технологийн Их Сургууль. Published by 2024. May 20 at 11:05 AM · Ulaanbaatar.

"MUST START-UP" ОЮУТНЫ ГАРААНЫ БИЗНЕСИЙН...

Оюутан залуусын гарааны бизнесийн уралдаан...

See More

26 13 Comments 4K Views

Like Comment Share

Comments

Most Relevant

Шинжлэх Ухаан Технологийн Их Сургууль 1:02:45 Баярлалаа

Like Reply Commented on by Sbr Nyak · 6d

Боллаа багалаа 1:09:33 Easy device bagt amjilt huysuee

Like Reply Message · 6d

View 6 more comments

Шүүгчдийн баг дараахи шалгуурын хүрээнд оноо өгч нийт шүүгчдийн дундаж онооны үзүүлэлтээр шилдэг багуудыг шалгарууллаа.

- Дэвшүүлж буй санаа нь шинэлэг бөгөөд инновацийн шийдэл агуулсан эсэх (Үйл ажиллагааг сайжруулсан, үйл явц, хэрэглээг хялбарчилсан)
- Санал болгож буй бизнесийн санаа хангалттай хэмжээний зах зээлтэй эсэх, зах зээлийн багтаамж
- Бизнес загвар /хэрэгжих боломжтой байдал/
- Цаашид бизнесийн санаа нь өсөж, хөгжих байдал
- Илтгэл (Санааг илэрхийлэх чадвар, баг үндсэн санаан дээрх хэрхэн нэгдсэн, бизнесийн санааг бүрэн илэрхийлсэн илэрхийлэмж, хугацаа)

Шүүгчдийн багийн шийдвэрээр “MUST Start-Up” тэмцээний шилдэгээр шалгарсан багууд:

- Тэргүүн байр

Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн сурах, хөгжих боломжоор хангах Робот зохион бүтээх санаа, технологийн шийдэл танилцуулсан ШУТИС-ийн Мэдээлэл холбооны технологийн сургуулиас оролцсон “ЛегоРобо” баг шалгарч 5 сая төгрөгийн судалгаа, хөгжүүлэлтийн грантын эзэд боллоо.

The image shows a certificate with a purple vertical bar on the left side. The main content is on a white background with a wavy pattern. At the top, there are three logos: the Mongolian State University of Information Technology (ШУТИС) logo, the 'Mongolian InnoWeek' logo, and the logo of the Mongolian Association for the Advancement of Science and Technology (МОНГОЛ УЛСЫН ШИНЖЛЭХ УХААН ТЕХНОЛОГИЙН ИХ СУРГУУЛЬ). The title 'Лего Робо' is written in a large, elegant, purple cursive font. Below it, the text reads: '“MUST Start-Up” оюутны гарааны бизнесийн уралдаанд **ТЭРГҮҮН** байранд шалгарсан тул'. The amount '5'000'000' is displayed in a large, bold, purple font. Below this, it says 'ТӨГРӨГИЙН СУДАЛГАА, ХӨГЖҮҮЛЭЛТИЙН ГРАНТ ОЛГОВ'. At the bottom, the text reads 'ШИНЖЛЭХ УХААН, ТЕХНОЛОГИЙН ИХ СУРГУУЛЬ' and '2021-05-20'.

БОЛОВСРОЛ, ШИНЖЛЭХ УХААНЫ
НАМ

MONGOLIAN
InnoWeek

МОНГОЛ УЛСЫН ШИНЖЛЭХ УХААН
ТЕХНОЛОГИЙН ИХ СУРГУУЛЬ

Лего Робо

“MUST Start-Up” оюутны гарааны бизнесийн
уралдаанд **ТЭРГҮҮН** байранд шалгарсан тул

5'000'000

ТӨГРӨГИЙН СУДАЛГАА, ХӨГЖҮҮЛЭЛТИЙН
ГРАНТ ОЛГОВ

ШИНЖЛЭХ УХААН, ТЕХНОЛОГИЙН ИХ СУРГУУЛЬ

2021-05-20

TEAM 1



Ц.ХҮРЭЛБААТАР



Г.ГАНТУЛГА



А.МӨНХ-ЭРДЭНЭ



Б.БИЛГҮҮН


ЛегоРобо

БАГИЙН НЭР

БАГА НАСНЫ ХҮҮХДЭД ЗОРИУЛСАН ОЮУНЫ ЧАДАМЖ
ХӨГЖҮҮЛЭХ УГСАРДАГ РОБОТ ТОГЛООМ.

- Хоёрдугаар байр

ШУТИС-ийн Дархан-Уул аймаг дахь Технологийн сургуулиас оролцсон “Darkhan IoT tracker” баг хоёрдугаар байранд шалгарав. Тэд IoT буюу зүйлсийн интернетийн технологи ашиглан аливаа зүйлсийн байршил тогтоох түүнийгээ нийгэмд хэрэглэж болох бүх л талбарт ашиглахаар ажиллаж байна. Тэд 3 сая төгрөгийн судалгаа, хөгжүүлэлтийн грант хүртлээ.



TEAM 39



Г.ХАСТУЛГА



УРАНЧИМЭГ



Г.ЭНХБОЛД



Л.УНДРАХ

Darkhan IoT Tracker

БАГИЙН НЭР

АВТОБУСНЫ БАЙРШИЛ ТОГТООХ ТӨХӨӨРӨМЖ. ТА ЦАГ
АА ХЭМНЭХ БОЛОМЖТОЙ БОЛЛОО.

- Гуравдугаар байр

Ахисан түвшний судлаач оюутны баг гуравдугаар байранд шалгарч 2 сая төгрөгийн судалгаа, хөгжүүлэлтийн грантын эзэд болов. ШУТИС-ийн Хэрэглээний шинжлэх ухааны сургуулийн “Pelos” баг нь шавар эмчилгээний усан хандын бэлдмэл гарган авах оюуны өмчөөр баталгаажсан технологио хөгжүүлэх юм.

The certificate is presented on a white background with a subtle wavy pattern. On the left, there is a vertical purple bar featuring a stylized graphic of a hand holding a gear. At the top, three logos are displayed: the Mongolian State University of Science and Technology (MSUST) logo, the 'MONGOLIAN INNOVATION Week' logo, and the logo of the Faculty of Applied Sciences, MSUST. The name 'Pelos' is written in a large, elegant, purple cursive font. Below it, a horizontal line separates the name from the award details. The text reads: '“MUST Start-Up” оюутны гарааны бизнесийн уралдаанд ГУТГААР байранд шалгарсан тул'. The amount '2'000'000' is prominently displayed in a large, bold, purple font. Below this, it states 'ТӨГРӨГИЙН СУДАЛГАА, ХӨГЖҮҮЛЭЛТИЙН ГРАНТ ОЛГОВ'. At the bottom, it identifies the awarding body as 'ШИНЖЛЭХ УХААН, ТЕХНОЛОГИЙН ИХ СУРГУУЛЬ' and includes the date '2021-05-20'.

БОЛОВСРОЛ ШИНЖЛЭХ УХААНЫ НАМ

MONGOLIAN INNOVATION Week

МОНГОЛ УЛСЫН ШИНЖЛЭХ УХААН ТЕХНОЛОГИЙН ИХ СУРГУУЛЬ

Pelos

“MUST Start-Up” оюутны гарааны бизнесийн уралдаанд **ГУТГААР** байранд шалгарсан тул

2'000'000

ТӨГРӨГИЙН СУДАЛГАА, ХӨГЖҮҮЛЭЛТИЙН ГРАНТ ОЛГОВ

ШИНЖЛЭХ УХААН, ТЕХНОЛОГИЙН ИХ СУРГУУЛЬ

2021-05-20

TEAM 14



Б.БАЯРАА



Г.ГАНЗАЯА



Б.ГАНЦЭЦЭГ


PELOS

БАГИЙН НЭР

ЭМЧИЛГЭЭНИЙ ШАВАРТАЙ ДҮЙЦЭХҮЙЦ
ҮЙЛЧЛЭЛТЭЙ ШАВРЫН УСАН ХАНДЫН БЭЛДМЭЛ,
ШАВАР ЭМЧИЛГЭЭГ ХЯЛБАР ХИЙХ БОЛОМЖТОЙ
БОЛЛОО

- Тусгай байр (IV)

“MUST Start-Up” тэмцээний тусгай байранд “Сивиллицкий –Аэрлети” баг шалгарч 600,000 төгрөгийн судалгаа, хөгжүүлэлтийн грант хүртэхээр болов. ШУТИС-ийн Механик тээврийн сургуулийн нисэх техникийн механикийн ангийн оюутнуудын багаас бүрдсэн тэд бага оврын нисэх техник зохион бүтээж түүнийгээ хэрэглээнд нэвтрүүлэхээр зорьж байна.



TEAM 12



**П.ГАЛТХҮҮ,
Б.МӨНХЖАВХЛАН
Б.ГАНЦООЖ**
Зүүн гар талаас




М.АМАРБАЯСГАЛАН

Сивиллицкий БАГИЙН НЭР

МАНАЙ БАГИЙН ХИЙСЭН ХҮРГЭЛТИЙН
ДРОН, НИСГЭГЧГҮЙ НИСЭХ СИСТЕМҮҮД АГААРЫН
ЗАМААР БАРАА ТЭЭВЭРЛЭХ БОЛНО.

- Тусгай байр (V)

ШУТИС-ийн Эрчим хүчний сургуулиас оролцсон AIA буюу Artificial Intelligent & Automation баг тусгай байранд шалгарч 400,000 төгрөгийн судалгаа, хөгжүүлэлтийн грант хүртэхээр боллоо. AIA баг нь эрүүл мэндийн Pharmed киоск төхөөрөмж зохион бүтээж хэрэглээнд нэвтрүүлэхээр ажиллаж байгаа юм.



The poster is for the AIA (Artificial Intelligent & Automation) grant. It features a purple vertical bar on the left with a stylized hand icon. The main content is on a white background with a wavy pattern. At the top, there are three logos: the Mongolian State University of Science and Technology (ШУТИС), the Mongolian InnoWeek 2021 logo, and the Mongolian State University of Science and Technology (МОНГОЛ УЛСЫН ШИНЖЛЭХ УХААН ТЕХНОЛОГИЙН ИХ СУРГУУЛЬ). The title 'Aia' is in a cursive font, followed by 'Artificial Intelligent & Automation' in a similar font. Below the title, it says '“MUST Start-Up” оюутны гарааны бизнесийн уралдаанд **ТУСГАЙ** байранд шалгарсан тул'. The amount '400'000' is prominently displayed in a large, bold, purple font. Below it, it says 'ТӨГРӨГИЙН СУДАЛГАА, ХӨГЖҮҮЛЭЛТИЙН ГРАНТ ОЛГОВ'. At the bottom, it says 'ШИНЖЛЭХ УХААН, ТЕХНОЛОГИЙН ИХ СУРГУУЛЬ' and '2021-05-20'.

БОЛОВСГОЛ ШИНЖЛЭХ УХААНЫ ГЭМ

MONGOLIAN InnoWeek 2021

МОНГОЛ УЛСЫН ШИНЖЛЭХ УХААН ТЕХНОЛОГИЙН ИХ СУРГУУЛЬ

Aia
Artificial Intelligent & Automation

“MUST Start-Up” оюутны гарааны бизнесийн уралдаанд **ТУСГАЙ** байранд шалгарсан тул

400'000

ТӨГРӨГИЙН СУДАЛГАА, ХӨГЖҮҮЛЭЛТИЙН ГРАНТ ОЛГОВ

ШИНЖЛЭХ УХААН, ТЕХНОЛОГИЙН ИХ СУРГУУЛЬ

2021-05-20

TEAM 15

О.МӨНХЖИН

Х.МӨНХЖАВХЛАН

Т.НОРОВХОРОЛ

Б.ГЭРЭЛТЦОЛМОН

Э.ЭНХГЭРЭЛ

Д.ӨГЭДЭЙ

AIA
(Artificial Intelligence & Automation)
БАГИЙН НЭР

24 ЦАГИЙН ТУРШ ЭМЭЭ ХЭРЭГЛЭХ ЗААВАРТАЙ НЬ
АВЧ, АМИН ҮЗҮҮЛЭЛТЭЭ ХЭМЖИХ БОЛОМЖТОЙ
PHARMED КИОСК, ЭМ АВАХАД ХЯЛБАР БОЛЛОО.

Ийнхүү “Монголын инновацийн 7 хоног” арга хэмжээний хүрээнд зохиогдсон “MUST Start-Up” уралдаан амжилттай зохион байгуулагдаж ШУТИС-ийн Технологи дамжуулах төв нь шилдэгээр шалгарсан болон нийт оролцсон багуудтайгаа хамтран ажиллаж эхэллээ. Тус арга хэмжээг олон нийтэд хүргэх ажилд MN Agency байгууллага хамтран ажиллалаа.

ШУТИС-ийн Технологи дамжуулах төв

ШУТИС-ийн Бизнесийн удирдлага, хүмүүнлэгийн сургууль